

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2022 оны 03 дугаар сарын 05-ны өдөр

№ГУЗТ 05/2022

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Даалгавар өгөх, Ноогдол ашигийн бодлого, шийдвэр
гаргах, мэдээлэх, тарааж олгож журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.12, 76.1.18, “Эрдэнэс сольюшинс ХК (“Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.10.4 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн охин компани “Эйс ассошиэйтс ББСБ” ХХК-ийн тухайн жил олсон цэвэр ашигийг 2023 оноос эхлэн 100 (нэг зуу) хувь хувьцаа эзэмшигчдэд хувиарлан, Компанид ноогдох ашигийн хувийг татан төвлөрүүлж байхыг Гүйцэтгэх захирал (Ц. Хүдэрмөнх)-д даалгасугай.
2. Компанийн “Ноогдол ашигийн бодлого, шийдвэр гаргах, мэдээлэх, тарааж олгож журам”-ыг 1-р хавсарлтаар баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Joint Stock
Company



/Т.ЗОЛБОО/



“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК-ИЙН НООГДОЛ АШГИЙН БОДЛОГО, ШИЙДВЭР ГАРГАХ, МЭДЭЭЛЭХ, ТАРААЖ ОЛГОХ ЖУРАМ

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн бодлогыг тодорхойлох, түүнийг хувиарлах шийдвэр гаргах, энэ талаарх мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хуваарилсан ногдол ашгийг тараах, тайлагнахад энэхүү бодлого, журмыг мөрдөнө.

Нэг. Ногдол ашгийн бодлого.

1.1. “Хар хорум пропертийс” ХК нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл, журмын хүрээнд ногдол ашгийн дор дурдсан бодлогыг хэрэгжүүлнэ:

1.1.1. Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйл, компанийн дүрмийн 6.6-д заасан ногдол ашиг хуваарилах нөхцлийг хангасан нөхцөлд ногдол ашиг хуваарилах.

1.1.2. Компанийн тухайн жилийн ногдол ашиг нь тухайн жилийн цэвэр ашигийн 50 болон түүнээс дээш хувиар хувьцаа эзэмшигчдэд олгох.

1.1.3. Компанийн ногдол ашгийн ойрын ба хэтийн бодлого, хуваарилалт нь ирээдүйд компанид хөрөнгө оруулалт татахуйц байх.

1.1.4. Хуваарилж буй ногдол ашгийн хэмжээ нь компанийн тухайн жилийн бодит боломжоос хэтэрхий дээгүүр, эсхүл хэтэрхий доогуур биш байх.

1.1.5. Хуваарилж буй ногдол ашгийн хэмжээг (тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд) бууруулахгүй байх бодлого баримтлах.

1.1.6. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилах.

1.1.7. Ногдол ашиг хуваарилах, эсэх тухай асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал танилцуулж, хэлэлцүүлдэг байх.

1.1.8. Хуваарилсан ногдол ашгийг аль болох мөнгөн хэлбэрээр олгох бөгөөд хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар тарааж олгох ажиллагааг хэрэгжүүлэх.

1.2 Энэхүү бодлогыг хэрэгжүүлэх үүргийг Төлөөлөн удирдах зөвлөл хүлээнэ.

Хоёр. Ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах, олгох, мэдээллэх, тайлагнах

2.1. Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд зааснаар ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөл эдэлнэ. Төлөөлөн удирдах зөвлөл ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг тухайн санхүүгийн жил дууссанаас хойш 50 дотор гаргана.

2.2. Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт тухайн төрлийн нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ, ногдол ашгийг олгож эхлэх хугацаа, 2 бүртгэлийн өдөр, ямар хэлбэр (бэлэн мөнгө, эд хөрөнгө, үнэт цаас гэх мэт)-ээр олгох болон хэрхэн тараах зэргийг тусгана.

2.3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэх өдөр нь тухайн тайлангийн жилийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэх өдөр байна.

2.4. Ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухай үндэслэлээ тухайн жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, хэрэв хуваарилан олгохоор шийдвэрлэсэн бол уг ногдол ашгийн тайланг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

2.5. Ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэдэг журмаар олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр хувьцаа эзэмшигчдэд хүргэнэ.

2.6. Ногдол ашиг хуваарилалтын тайланг тогтоосон журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлнэ.

2.7. Ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Компанийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.